



ХЭНТИЙ АЙМГИЙН
ДАДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 11111

Баян-Овоо

Хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй
зээл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хүнс, Хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрийн сайдын А/361 дүгээр тушаалын хавсралтын 6 дугаар зүйлийн 6.7, 6.11 дэхь заалт, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 02 дугаар тогтоол, Хоршоо хөгжүүлэх сангийн төсөл сонгон шалгаруулах хорооны 2024 оны 07 дугаар сарын 24-ны өдрийн 01 дүгээр шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих, аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх зорилгоор Хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл авах жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн нэрсийг хавсралтаар баталсугай.

2. Тус сангаас зээл авч байгаа иргэдийн зээлийг зориулалтын дагуу үйл ажиллагаа явуулж буй эсэх, хүүгийн болон үндсэн төлөлтөө гэрээнд заасны дагуу төлж буй эсэхэд байнгын хяналт тавьж ажиллахыг тус хорооны нарийн бичгийн дарга, Хүнс, жижиг дунд үйлдвэрлэл, хоршооны асуудал мэргэжилтэн (М.Анаржин), сангийн нягтлан бодогч (Д.Даваадорж) нарт тус тус даалгасугай.

3. Төслийн санхүүжилтээр олгогдсон зээлийн мөнгөн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах, эргэн төлөлтөө цаг хугацаанд нь санд төвлөрүүлэх, ажлын бйр шинээр бий болгоход анхаарч, үр дүнтэй ажиллахыг төсөл хэрэгжүүлэх жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдэд анхааруулсугай.

4. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг төсөл сонгон шалгаруулах хорооны дарга, Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Гэрэлмаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.МӨНХ-ОД



010000293

Сумын Засаг даргын 2024 оны 07 дугаар
сарын 24-ны өдрийн 111 дугаар
захирамжийн хавсралт

Хоршоо хөгжүүлэх сангаас жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ, аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх зорилгоор хөнгөлөлттэй зээл авах жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн нэрс

№	Жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн нэр	Төслийн нэр	Зээлийн хэмжээ /сая, төг/
1	П.Энхсайхан	Орон нутгийн эмэгтэйчүүдийг ажлын байраар хангах	9.000.000
2	Ц.Ганхүү	Авто засвар, дугуй засвар, цахилгаан гагнуур	14.000.000
3	О.Дашпүрэв	Дугуй засвар өргөжүүлэх авто засвар байгуулах	17.000.000
4	Э.Болортуяа	Нархан тохижилт	15.000.000
Нийт дүн			55.000.000